



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЯРЦОГТ
ТАНАА

2017.03.15 № 3/460
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Санхүүгийн Аудитын Газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим
хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим
хаяг:sambuunyamyа@audit.gov.mn

Эс Жи Эм Ди Аудит ХХК
Утас: 7000 6948
Цахим хаяг:info@sgmd-audit.mn,
ekhbayar@ sgmd-audit.mn

Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Агуулга
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Зорилтод түвшний биелэлт

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дугаар заалтыг тус тус үндэслэн Үндэсний Аудитын Газрын бүрэн эрхийн хүрээнд “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/67/СТА-ТӨХК/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“ЭБЦТС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“ЭБЦТС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 9 дүгээр сарын 20-нөөс 2017 оны 3 дугаар сарын 6-ны хооронд хийхээр төлөвлөн “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудиторууд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“ЭБЦТС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-нд “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-т ирүүлсэн байна.

“Эс Жи Эм Ди - Аудит” ХХК нь аудитыг зохих стандартын дагуу гүйцэтгэж, хуулийн хугацаанд аудитын тайланг “ЭБЦТС” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

Хоёр. Компанийн хууль, эрх зүйн орчин:

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Эрчим хүчний тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Компанийн тухай”, НББ, Татварын багц хууль, НД-ийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг журам, зааварт өөрчлөлт ороогүй, НББ-ийн тухай хууль 2016.1.1-нээс шинэчлэгдэн мөрдөгдсөн.

Гурав. Компанийн зорилго, үйл ажиллагаа:

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь байгууллагынхаа үйл ажиллагааны зорилго зорилтыг:

Эрхэм зорилго - Хэрэглэгчдийг найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчээр хамгийн бага алдагдалтайгаар хангаж, борлуулсан эрчим хүчний орлогыг хамгийн богино хугацаанд цуглуулах.

Зорилт - Хангайн бүсийн нутаг, дэвсгэрийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр жигд найдвартай, тасралтгүй бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч түгээх, борлуулах үйлдвэрлэл эрхэлж, цахилгаан эрчим хүчний шугам, тоног төхөөрөмжийн угсралт, засварын ажил үйлчилгээ үзүүлнэ гэж дүрмэндээ тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана. Захирлыг Төрийн өмчийн хороо, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасан байна.

ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд тус компани нь компанийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, эрчим хүчний тухай болон холбогдох бусад хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ЭБЦТС” ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан. ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 7-ны 18 дугаар тогтоолоор гүйцэтгэх захиралаар Г.Баярцогт томилогдон ажиллаж байна. Мөн ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогч, захиргаа удирдлагын дарга нар шинээр томилогдсон. ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 24-ны 25 дугаар тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн байгуулж 4 салбар, 7 хэлтэс, 2 хэсэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /НББОУС/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 203 дугаар тушаалаар батлагдсан Санхүүгийн тайлангийн аудитын журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “ЭБЦТС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын

эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 41-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “ЭБЦТС” ТӨХК нь 2016 онд санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх НББОУС-ын дагуу боловсруулсан НБББББ-ийг цаашид ашиглахдаа сайжруулах шаардлагатай, Ньюрадианс ХХК-ийн Unicus нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай байна.

“ЭБЦТС” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулгын аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“ЭБЦТС” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Материаллаг байдал:

Гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-1 маягтыг ашиглан материаллаг байдлын түвшинг тогтохдоо нийт орлогыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв. “ЭБЦТС” ТӨХК-ийн нийт хөрөнгийн дүн болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тооцоход хэтэрхий өндөр байгаа юм. Мөн үнэ тариф өссөнтэй холбоотойгоор нийт орлого байнга өсч байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг нийт орлогын 1.0 хувиар буюу 1,759.8 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзлээ. Энэ үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

Зургаа. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн түрш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“ЭБЦТС” ТӨХК нь 2014 оны 1 дүгээр сарын 6-наас Хяналтын хэлтсийг байгуулж нийт 5 ажилтантай ажиллахаар бүтэц, орон тоог зохион байгуулсан. 2014 оны 6 сарын 1-ээс дотоод аудитор ажиллуулж эхэлсэн. 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс дотоод хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс болж 4 ажилтантай ажиллаж байна. Хяналтын хэлтэс, аюулгүй ажиллагааны хэлтэс нь гүйцэтгэх удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хэлтсийн ажлын төлөвлөгөөний дагуу компанийн бүхий л үйл ажиллагааны чиглэлийн хяналт шалгалтыг хийж, зөвлөмж, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах үүрэгтэй байна.

Компанийн дотоод аудитын ажилтан нь 2016 онд давхардсан тоогоор 10 удаа санхүүгийн баримтын шалгалт хийж, хяналт шалгалт болон санхүүгийн

тайлангийн 1, гүйцэтгэлийн 1, нийцлийн 1, нийт 11 шалгалт, аудит хийлээ. Хяналт шалгалт, аудитаар нийт 240.4 сая төгрөгийн үнийн дүнтэй зөрчил дутагдал илрүүлж, 224.5 сая төгрөгийн үнийн дүнтэй албан шаардлага өгч, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг гаргуулжээ. Хяналт шалгалтыг хийснээр 57 зөрчил дутагдлыг илрүүлэн 7 албан шаардлага зөвлөмж, хугацаат үүрэг даалгаврыг өгч, ажилласнаар үүний 30 гаруй хувийг газар дээр нь буюу заасан хугацаанд нь арилгуулсан байна.

Эрсдэлийн үнэлгээ хийвэл зохих 13,905 ажлын байрны 1,831 цэгт, анхан шатны 258 цэгт дахин үнэлгээ хийж, 228 цэгт эрсдэлийг бууруулсан.

Долоо. Компанийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Эрчим хүчний сайдын 2016 оны 3 дугаар сарын 11-ний 40 дүгээр тогтоолоор, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “ЭБЦТС” ТӨХК-ний 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 167,927.4 сая төгрөгийн орлого, 167,927.4 сая төгрөгийн зардал гаргаж тэг төгрөгийн ашиг алдагдалтай ажиллах төлөвлөгөө баталсан байна.

“ЭБЦТС” ТӨХК нь 2016 онд нийт 175,984.5 сая төгрөгийн орлого олж, 175,875.96 сая төгрөгийн зардал гаргаж 69.6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Орлогын төлөвлөгөөг 104,8 хувиар биелүүлж, зардлын төлөвлөгөө 104.7 хувийн гүйцэтгэлтэй гарч төлөвлөгөөт ашгийг 69.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар судлаж үзэхэд “Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК нь 2015 оны 1 сарын 1-нээс шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Компанийн 2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөө гүйцэтгэл, 2016 оны худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө мөн 5 сая төгрөгнөөс дээш мөнгөн хөрөнгийн мэдээллийг shilendans.gov.mn, www.edc.mn сайтад тухай бүр байршуулж байна. Мөн байгууллагын мэдээллийн самбараар мэдээллийг ил тод байршуулж байсан.

Үйл ажиллагааны зардлын 467.6 сая төгрөгийн мэдээллийг 185 удаа давтамжтай, худалдан авах ажиллагаатай холбогдуулан 3,910.6 сая төгрөгийн мэдээллийг 268 удаа давтамжтай, нийт 4,378.2 сая төгрөгийн мэдээллийг 453 удаа давтамжтайгаар илэрхийлсэн байна. Гэвч зарим мэдээллийн хувьд хэт товч ялангуяа хөрөнгө зарцуулах тушаалын талаар мэдээлэл тавихдаа хавсралтыг тавьдаггүй байдал ажиглагдлаа.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 36 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 41 нарийвчилсан горим, сорил

гүйцэтгэв. Мөн Архангай, Булган, Өвөрхангай, Хархорин салбар, Архангай аймгийн Цэцэрлэг, Хайрхан, Эрдэнэмандал сумдад ажиллаж тусгайлсан горим, сорилыг тус бүрт гүйцэтгэж ажилласан.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“ЭБЦТС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, худалдан авалт (бараа материал), өр төлбөр, байгууллагын үйл ажиллагааны орлого, борлуулалтын өртөг, ерөнхий удирдлагын болон борлуулалт маркетингийн зардал зэрэг дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 20.7 хувь, мөнгөн хөрөнгийн 55.0 хувь, нийт зардлын 39.3 хувь, нийт хөрөнгийн 63.8 хувийг тус тус эзэлж байна.

Ажилчдын тэтгэмж, буцалтгүй тусламж, шагнал урамшуулал, баяр ёслолын арга хэмжээнд 467,6 сая төгрөгийг зарцуулсан зардлын гүйлгээг онцлох гүйлгээнд авч үзэж болох юм.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илрээгүй байна

Арван хоёр. Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тус байгууллагын цалин хөлсний тооцоог аудитын түүврийн арга хэрэглэн Эрдэнэт салбарын 4-р улирлын цалин хөлсийг шалгахад:

а. Ээлжийн амралтыг бодохдоо дундаж цалинд ХЧАТэтгэмж, хоол, унааны мөнгө, ЭХТАН зэрэг нэмэгдлүүдийг оруулж тооцсон байдал Эрдэнэт салбар дээр ажиглагдсан. /дундаж цалинг 7.5 сая төгрөгөөр өсгөж бодсон/

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55-р тушаалаар баталсан дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4-р зүйлийг бүх салбаруудад мөрдөн хэрэгжүүлж ажиллах

б. Ажилтнуудын цалингаас тусламж /хамтын сан/ утасны төлбөр, зарим өр, авлагыг суутгасан байдал нийт салбарын хэмжээнд ажиглагдлаа.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хуулийн 63-р зүйлийн 1,2,3,4,5-р заалтуудыг бүх салбаруудад мөрдөн хэрэгжүүлэх

2. 2016 оны санхүүгийн тайлангийн татвар ноогдох орлогоос хасагдахгүй зардал 42.8 сая төгрөгийг санхүүгийн зохицуулалтын тайлангаар зөрүүд тусгаагүй нь татвар төлөхөөс зайлсхийсэн эрсдэл үүсэж болзошгүй байдал ажиглагдлаа.

Шийдвэрлэсэн нь: ААНОАТ-ын хуулийн 12,13,14-р зүйлүүдэд татвар ногдох орлогоос хасах зардлуудыг заасан. Иймээс эдгээр заалтуудад хамаарахгүй болон татварын зорилгоор хасагдахгүй шинж чанар бүхий зардлуудыг санхүүгийн тайланд бүртгэсэн бол түүнийг "Татварын өмнөх ашигт-т нэмж, орлогын албан татварыг зөв тодорхойлж, татварын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх

- 3.Тус байгууллага нь ойн арга хэмжээ 7.9 сая төгрөг, цагаан сар, ахмадын баярт 5.5 сая төгрөг, манжуурын аялалд 4.4 сая төгрөг, хүлээн авалтын зардалд 2.6 сая төгрөг нийт 20.4 сая төгрөг зарцуулагдсан байдал ажиглагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Засгийн газрын 2014 оны 147-р тогтоолын 3.6-р зүйлд заасан" гадаад дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх"гэсэн заалтыг мөрдөж ажиллах

2.Төсвийн тухай хуулийн 6.4.1-д зүйлд заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.2-т заасан төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх заалтыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах

4. Өвөрхангай салбар нь суудлын автомашин 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1.харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар; 8.2.Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ заалтыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах.

5. 2016 онд ЭБЦТС ТӨХК-ний Булган салбарын ХААН банкин дахь төгрөгийн 5270001032 тоот дансанд 6.6 сая төгрөгийн цахилгааны орлогын мөнгө,Төрийн банкны 120000295891 тоот дансанд 1.3 сая төгрөгийн цахилгааны орлогын мөнгийг тус тус төвлөрүүлэн авч үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэхэд ашигласан байна. Эдгээр цахилгааны орлогын мөнгө болох нийт 7.9 сая төгрөгийг бусад орлогоор орлого үр дүнгийн тайланд тайлагнаж,"Тэг үлдэгдэлтэй данс"-д төвлөрүүлээгүй байна.Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 17.2.3-т заасан "цахилгаан, дулаан дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөрийг төлөх" заалт болон ДҮТ ХХК-тай хийсэн гэрээний 3.1-д заасан " Худалдан авагч нь энэ гэрээнд заасан цахилгаан эрчим хүчийг худалдан авах төлбөрийг сар бүр төвлөрүүлэх үүрэгтэй " гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахилгааны орлогын мөнгийг үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлдэг дансандаа төвлөрүүлэн авч үйл ажиллагаандаа зарцуулахгүй байх, зөрчлийг арилгах акт тавих

6. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд дансны авлага дансны үлдэгдэлд 27.8 сая төгрөгийн ажилтан албан хаагчдын цалингаас бусад урьдчилгааны дансны үлдэгдлийг оруулан тайлагнасан байна. Дансны өглөг дансны үлдэгдэлд бусад өглөг дансны үлдэгдэл болох 106.9 сая төгрөгийг оруулан тайлагнасан байна. Ингэж тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 3 сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2012 оны 03 сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэх талаар зөвлөмж өгөх

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн эргэн төлөгдөх нөхцөлтэй 1,764.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг эздийн өмчийн бусад хэсэг дансанд эсвэл өр төлбөр үүсгэх тухайд бүрэн хэмжээнд мөшгин шалгаж амжаагүй болно.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 30,800.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 30,742.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 50.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7.9 сая төгрөгийн акт хүргүүлсэн болно.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн хийсэн аудитаар нийт 7,642.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 6,574.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 1,068.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д 4 зөвлөмж өгсөн байна. 2015 оны санхүүгийн тайлангийн зөрчлийг арилгаж, 4 зөвлөмж, албан шаардлагыг 75 хувийн биелэлттэй гүйцэтгэсэн байна.

Тэг үлдэгдэлтэй “Төвийн бүсийн Дамжуулах Үндэсний Төв”-д орлого төвлөрүүлэх “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн харилцах данснаас Татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийг суутгасан зөрчил давтан гарсан байна.

Арван долоо. Зөвлөмж

“Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын гүйцэтгэлийн шатанд нийт 8 зөвлөмж, 1 акт, 1 албан шаардлагыг тус тус боловсруулан хүргүүлж байна.

Арван найм. Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан болон өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд, тайлан, холбогдох хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 4 хуудас, хавсралтууд тус тус хавсаргав.



ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

“Тэг үлдэгдэлтэй данс”-ны талаар2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Дансны ангиллын талаар.....3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3

Дансны авлага, өглөгийн
талаар.....4

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 4

Цалин хөлсний талаар.....5

Тэргүүлэх ач холбогдол №5 зүйлс:

Асуудал 5

Зардлын талаар6

Тэргүүлэх ач холбогдол №6 зүйлс:

Асуудал 6

Зардлын талаар.....7

Асуудал 7

Худалдан авах ажиллагааны
талаар.....8

Асуудал 8

Өмнөх оны аудитын зөвлөмж талаар9

2016 оны 3 дугаар сар 3

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: “Тэг үлдэгдэлтэй данс”-ны талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. 2016 онд ЭБЦТС ТӨХК-ийн Булган салбарын ХААН банкин дахь төгрөгийн 5270001032 тоот дансанд 6.6 сая төгрөгийн цахилгааны орлогын мөнгө,

Төрийн банкны 120000295891 тоот дансанд 1.3 сая төгрөгийн цахилгааны орлогын мөнгийг тус тус төвлөрүүлэн авч үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэхэд ашигласан байна. Эдгээр цахилгааны орлогын мөнгө болох нийт 7.9 сая төгрөгийг бусад орлогоор орлого үр дүнгийн тайланд тайлагнаж, “Тэг үлдэгдэлтэй данс”-д төвлөрүүлээгүй байна. Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 17.2.3-т заасан “цахилгаан, дулаан дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх үйлчилгээний төлбөрийг төлөх” заалт болон ДҮТ ХХК-тай хийсэн гэрээний 3.1-д заасан “Худалдан авагч нь энэ гэрээнд заасан цахилгаан эрчим хүчийг худалдан авах төлбөрийг сар бүр төвлөрүүлэх үүрэгтэй “ гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

- Цахилгааны төлбөртэй холбоотой Дансны авлага дансны үлдэгдэл зөрүүтэй тайлагнахад нөлөөлөх,
- Төлөөлөн Удирдах Зөвлөл, Санхүүгийн тайланг хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд нөлөөлнө,
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

ҮАГ-ын зөвлөмж

1. Үйл ажиллагааны зардлын санхүүжилтэнд ашигласан цахилгааны орлогын мөнгийг “Тэг үлдэгдэлтэй данс”-д нөхөн төвлөрүүлж, цахилгааны төлбөрийн авлагатай холбоотой дансны авлага, дансны үлдэгдлээ үнэн зөвөөр тайлагнах

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал ангиллын талаар	2: Дансны	Тэргүүлэх ач холбогдол №2
------------------------------------	------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд дансны авлага дансны үлдэгдэлд 27.8 сая төгрөгийн ажилтан албан хаагчдын цалингаас бусад урьдчилгааны дансны үлдэгдлийг оруулан тайлагнасан байна. Дансны өглөг дансны үлдэгдэлд бусад өглөг дансны үлдэгдэл болох 106.9 сая төгрөгийг оруулан тайлагнасан нь Сангийн сайдын 2012 оны 03 сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-г зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2012 оны 03 сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-г даган мөрдөж санхүүгийн тайлангаа тайлагнах.

Эрсдэлүүд

- Санхүүгийн тайлангийн уялдаа холбоо буруу илэрхийлэгдэх
- Дансны өглөг, авлагын үлдэгдэл санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлэгдэх
- Төлөөлөн Удирдах Зөвлөл, Санхүүгийн тайланг хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд нөлөөлнө,

Удирдлагын хариу.

Асуудлын бүртгэлээр
танилцуулсан

Асуудал 3: Дансны авлага, өглөгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №3
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. Тус компани 13,685.0 сая төгрөгийн дансны авлагын, 14,012.2 сая төгрөгийн дансны өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

- Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх,

ҮАГ-ын зөвлөмж

1. Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Удирдлагын хариу.

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал 4: Цалин хөлсний талаар	Тэргүүлэх ач холбогдол № 4
--	-----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. Тус байгууллагын цалин хөлсний тооцоог аудитын түүврийн арга хэрэглэн Эрдэнэт салбарын 4-р улирлын цалин хөлсийг шалгахад:

а. Ээлжийн амралтыг бодохдоо дундаж цалинд ХЧАТэтгэмж, хоол, унааны мөнгө, ЭХТАН зэрэг нэмэгдлүүдийг оруулж тооцсон байдал Эрдэнэт салбар дээр ажиглагдсан. /дундаж цалинг 7.5 сая төгрөгөөр өсгөж бодсон/

б. Ажилтнуудын цалингаас тусламж /хамтын сан/ утасны төлбөр, зарим өр, авлагыг суутгасан байдал нийт салбарын хэмжээнд ажиглагдлаа.

Эрсдэлүүд

- Энэ нь аудитын үнэн зөв байдал: “Санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ нь зөв бүртгэсэн түүнийг зохицуулж буй хууль тогтоомжтой нийцэж байх” гэсэн батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55-р тушаалаар баталсан дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4-р зүйлийг бүх салбаруудад мөрдөн хэрэгжүүлж ажиллах

2. Хөдөлмөрийн тухай хуулийн 63-р зүйлийн 1,2,3,4,5-р заалтуудыг бүх салбаруудад мөрдөн хэрэгжүүлэх

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал 5: Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол № 5
----------------------------------	-----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. 2016 оны санхүүгийн тайлангийн татвар ноогдох орлогоос хасагдахгүй зардал 42.8 сая төгрөгийг санхүүгийн зохицуулалтын тайлангаар зөрүүд тусгаагүй нь татвар төлөхөөс зайлсхийсэн эрсдэл үүсэж болзошгүй байдал ажиглагдлаа.

ҮАГ-ын зөвлөмж

1. ААНОАТ-ын хуулийн 12,13,14-р зүйлүүдэд татвар ногдох орлогоос хасах зардлуудыг заасан. Иймээс эдгээр заалтуудад хамаарахгүй болон татварын зорилгоор хасагдахгүй шинж чанар бүхий зардлуудыг санхүүгийн тайланд бүртгэсэн бол түүнийг “Татварын өмнөх ашигт-т нэмж, орлогын албан татварыг зөв тодорхойлж, татварын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх

Эрсдэлүүд

- “Санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ нь зөв бүртгэсэн түүнийг зохицуулж буй хууль тогтоомжтой нийцэж байх” гэсэн батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх.

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал 6: Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №6
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. Тус компани нь ойн арга хэмжээнд 7.9 сая төгрөг, цагаан сар ахмадын баярт 5.5 сая төгрөг, манжуурын аялалд 4.4 сая төгрөг, хүлээн авалтын зардалд 2.6 сая төгрөг нийт 20.4 сая төгрөг зарцуулагдсан байдал ажиглагдаж байна.

ҮАГ-ын зөвлөмж

- 1 Засгийн газрын 2014 оны 147-р тогтоолын 3.6-р зүйлд заасан "гадаад дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах
2. Төсвийн тухай хуулийн 6.4.1-д зүйлд заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.2-т заасан төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх заалтыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

- Зохих хууль тогтоомжууд хэрэгжихгүй, төрийн өмчийг үр ашиггүй зарцуулагдах эрсдэлд хүргэнэ.

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал 7: Худалдан авах ажиллагааны талаар	Тэргүүлэх ач холбогдол №7
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

- 20 нээлттэй тендер шалгаруулалт зарлахаар төлөвлөснөөс 5 төрлийн барааг тоо,ширхэгийг нь цөөлж, харьцуулалтын аргаар худалдан авсан.Үүнд: 1.10 кВ-ын ваакум таслуур, удирдлагын блок, хамгаалалтын хамт иж бүрдлээр нь 4-ийг 80.0 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж байсныг 3-ыг 48.0 сая төгрөгөөр 2.35 кВ-ын хүчдлийн трансформатор 10-ыг 55.0 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж байсныг 9-ийг 49.5 сая төгрөгөөр 3.0,4-10 кВ-ын кабель 2036 м-ийг 56.7 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж байсныг 1500 м-ийг 37.0 сая төгрөг 4.КТПН/трансформаторгүй/ 6 иж бүрдлийг 60.0 сая төгрөгөөр авахаар төлөвлөж байсныг 5-ыг 49.9 сая төгрөгөөр 5.1 фазын тоолуур 1750 ширхэгийг 78.7 сая төгрөгөөр авахаар төлөвлөж байсныг 1,110 ширхэгийг 49.9 сая төгрөгөөр тус тус авах гэрээ хийгдсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4, 8.5, "8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно." заалтыг тус тус зөрчсөн байна. Мөн ТУЗ-аас зөвшөөрөл аваагүй байна.

Эрсдэлүүд

- Хууль тогтоомж хэрэгжихгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

- Худалдан авах ажиллагаандаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4, 8.5, заалтуудыг дагаж мөрдөж ажиллах, Мөн ТУЗ-д танилцуулж, зөвшөөрөл авч байх,

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

Асуудал 8: Өмнөх оны аудитын зөвлөмж талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1. ТӨХ-ний 2015 оны 3 сарын 11-ний 3/602 тоот БНЧех улсын хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлсэн "Евро эко Төгөл" төслөөр санхүүжсэн 1,764.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн эх үүсвэрийг тодорхой болгох өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

- Үнэн зөв байх батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

1. Эх үүсвэрийг тодорхой болгох ул үндэслэлтэй нотолгоо олж авч бүртгэлд тусгах (НББОУС 20.8-10)

Удирдлагын хариу

Асуудлын бүртгэлээр танилцуулсан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

" ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ " ТӨХК

/Аж ахуйн нэгжийн нэр/

2016 оны 12 сарын 31 өдөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	321,062,096.19	4,101,435,400.40
1.1.2	Дансны авлага	13,686,559,461.77	13,685,071,583.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	6,782,068.10	
1.1.4	Бусад авлага	182,968,722.18	162,707,576.57
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,721,603,420.62	1,904,684,098.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		3,976,856.07
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,918,975,768.86	19,857,875,514.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	121,052,182,196.14	117,437,892,656.49
1.2.2	Биет бус хөрөнгө	19,099,015.16	110,916,439.35
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		140,473,063.84
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	121,071,281,211.30	117,689,282,159.68
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	136,990,256,980.16	137,547,157,673.76

2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	13,319,699,327.50	14,012,206,522.74
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	220,498,084.62	112,554,940.12
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	60,000,000.00	
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	3,060,254,096.20	189,148,584.05
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	16,660,451,508.32	14,313,910,046.91

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	259,277,389.43	368,575,867.45
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		2,690,248,713.40
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	259,277,389.43	3,058,824,580.85
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	16,919,728,897.75	17,372,734,627.76
2.3	2. Эзэмшигчийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	36,133,095,200.00	119,534,968,376.11
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	82,251,661,395.84	
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	1,150,211,780.27	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	535,559,706.30	639,454,669.89
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	120,070,528,082.41	120,174,423,046.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	136,990,256,980.16	137,547,157,673.76

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

" ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ " ТӨХК

/Аж ахуйн нэгжийн нэр/

2016 оны 12-р сарын 31

Мөрийн дугаар	Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	150,251,673,590.15	175,289,315,871.03
2	Борлуулалтын өртөг	132,103,517,507.18	154,850,939,021.38
3	Нийт ашиг /алдагдал/	18,148,156,082.97	20,438,376,849.65
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	4,100,258.17	22,458,993.17
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	564,037,180.87	671,604,333.90
9	Борлуулалт, маркетингийн зардал	47,115,200.00	27,140,533.50
10	Ерөнхий ба удирдлагын зардал	15,407,901,600.97	20,859,274,597.55
11	Санхүүгийн зардал		3,230,003.15
12	Бусад зардал	49,212,700.00	58,091,853.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	217,237.21	990,325.16
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-20,065,270.13	-8,883,444.14
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-79,185,600.00	-68,132,436.93
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,113,030,388.12	108,677,633.61
19	Орлогын татварын зардал	96,565,407.20	2,245,899.31
19.1	Хойшлогдсон татварын зардал	259,277,389.43	36,823,891.97
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,757,187,591.49	69,607,842.33
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	2,757,187,591.49	69,607,842.33
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
	Орлогын нийт дүн	2,757,187,591.49	69,607,842.33
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

" ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ " ТӨХК

/Аж ахуйн нэгжийн нэр/

2016 оны 12-р сарын 31

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 01 сарын 01 үлдэгдэл	17,913,596,300.00		13,739,138,771.97	4,480,360,183.84			-2,119,627,885.19	34,013,467,370.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-3,940,459,949.47	82,251,661,395.84		1,150,211,780.27		79,461,413,226.64
3	Залруулсан үлдэгдэл	17,913,596,300.00	0.00	9,798,678,822.50	86,732,021,579.68	0.00	1,150,211,780.27	-2,119,627,885.19	113,474,880,597.26
4	Тайлант үеийн цэвэр ашиг							2,757,187,591.49	2,757,187,591.49
5	Бусад дэлгэрэнгүй орлого			3,940,459,949.47					3,940,459,949.47
6	Өмчид гарсан өөрчлөлт	18,219,498,900.00		-13,739,138,771.97	-4,480,360,183.84				-55.81
7	Зарласан ногдол ашиг							-102,000,000.00	-102,000,000.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								0.00
9	2016 оны 01 сарын 01 үлдэгдэл	36,133,095,200.00	0.00	0.00	82,251,661,395.84	0.00	1,150,211,780.27	535,559,706.30	120,070,528,082.41
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							84,287,121.26	84,287,121.26
11	Залруулсан үлдэгдэл	36,133,095,200.00	0.00	0.00	82,251,661,395.84	0.00	1,150,211,780.27	619,846,827.56	120,154,815,203.67
12	Тайлант үеийн цэвэр ашиг							69,607,842.33	69,607,842.33
13	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	83,401,873,176.11			-82,251,661,395.84		-1,150,211,780.27		0.00
15	Зарласан ногдол ашиг							-50,000,000.00	-50,000,000.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								0.00
17	2016 оны 12 сарын 31 үлдэгдэл	119,534,968,376.11	0.00	0.00	0.00	0.00	0.00	639,454,669.89	120,174,423,046.00

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

" ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ " ТӨХК

/Аж ахуйн нэгжийн нэр/

2016 оны 12-р сарын 31

Мөрийн дугаар	Үзүүлэлтүүд	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	168,557,481,350.91	215,387,526,012.84
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	152,308,442,456.13	192,317,595,212.22
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,257,377.00	1,168,307.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	14,729,460,974.20	21,542,007,340.63
	Бусад мөнгөн орлого	1,516,320,543.58	1,526,755,152.99
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-168,071,339,941.13	-209,936,017,209.83
	Ажиллагчдад төлсөн	-6,551,779,316.91	-7,237,341,812.40
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-1,767,749,404.85	-1,830,503,324.23
	Бараа материал худалдан авахад төлсөн	-2,491,524,327.03	-3,046,679,345.33
	Ашиглалтын зардалд төлсөн	-107,319,072.30	-89,794,485.59
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-791,140,615.06	-840,375,101.40
	Хүүний төлбөрт төлсөн	-5,556,712.32	-2,542,913.32
	Татварын байгууллагад төлсөн	-2,361,700,857.26	-2,443,990,786.47
	Даатгалын төлбөрт төлсөн	-11,323,686.00	-10,582,065.00
	Бусад мөнгөн зарлага	-153,983,245,949.40	-194,434,207,376.09
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	486,141,409.78	5,451,508,803.01
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,700,000.00	1,100,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	2,700,000.00	1,100,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-508,169,900.00	-1,562,235,498.80
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-507,569,900.00	-1,562,235,498.80
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-600,000.00	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-505,469,900.00	-1,561,135,498.80
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	100,000,000.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	100,000,000.00	

	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-142,000,000.00	-110,000,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-40,000,000.00	-60,000,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	-102,000,000.00	-50,000,000.00
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-42,000,000.00	-110,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-61,328,490.22	3,780,373,304.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	382,390,586.41	321,062,096.19
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	321,062,096.19	4,101,435,400.40
	Нийт зөрүү	-61,328,490.22	3,780,373,304.21